



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/335

Номгон

Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмжийг шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах, санхүүжилтийг олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/ дахь заалт, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XVII.1.12, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Аймаг орон нутагт эрх шилжүүлэх хуваарь батлах тухай” А-33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тухайн ажлыг 4 багц болгон тендерийг зарласан бөгөөд 1 дүгээр багц буюу малын шимэгчтэх өвчнийг оношлох, шинжлэх лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд “Синапс” ХХК-тай, 3 дугаар багц буюу мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нийлүүлэх ажилд “Бат билэг гурван эрдэнэ” ХХК-тай, 4 дүгээр багц буюу малын шимэгчтэх өвчний угаалгын ванн хийх ажилд “Жаргантайн хөх тариа” ХХК-тай гэрээ байгуулах, 2 дугаар багц буюу малын шимэгчтэх өвчнийг оношлох, шинжлэх лабораторийн тусгай зориулалттай эд хогшил нийлүүлэх ажлыг 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн б/48 тоот зөвлөмжийн дагуу дахин тендер зарлуулахаар зохион байгуулсугай.

2.Дээрх шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.


3.Тус ажлын 1 дүгээр багц буюу малын шимэгчтэх өвчнийг оношлох, шинжлэх лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд “Синапс” ХХК-тай 345.031.280 /Гурван зуун дөчин таван сая гучин нэгэн мянга хоёр зуун наян төгрөгөөр, 3 дугаар

621010853

2.

багц буюу мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нийлүүлэх ажилд “Бат билэг гурван эрдэнэ” ХХК-тай 350,654,000 /Гурван зуун тавин сая зургаан зуун тавин дөрвөн мянган төгрөг/-өөр, 4 дүгээр багц буюу малын шимэгчтэх өвчний угаалгын ванн хийх ажилд “Жаргантайн хөх тариа” ХХК-тай 145.559.808 /Нэг зуун дөчин таван сая таван зуун тавин есөн мянга найман зуун найман төгрөг/-өөр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.1 дүгээр багц буюу малын шимэгчтэх өвчнийг оношлох, шинжлэх лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх, 3 дугаар багц буюу мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нийлүүлэх, 4 дүгээр багц буюу малын шимэгчтэх өвчний угаалгын ванн хийх ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын хөдөө аж ахуй, дэд бүтэц хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН